**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 22 өдөр Дугаар А/173 Улаанбаатар хот

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.10 дахь хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5, Боловсролын ерөнхий хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3, 31.1.5, 31.1.6, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч хөгжих, бие даан амьдрах чадвар олгоход хүртээмжтэй таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дүүргийн Насан туршийн суралцахуйн төвийн тусгай хэрэгцээт сурагчдад боловсрол олгох танхимыг стандартын шаардлагад нийцүүлэн тохижуулж, сургалтын хэрэглэгдэхүүн олгох ажлыг зохион байгуулсугай.

2.Сургалтын хэрэглэгдэхүүн болон орчны тохижилтод шаардагдах төсвийг хавсралтаар баталж, 1,650,400 (Нэг сая зургаан зуун тавин мянга дөрвөн зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Сургалтын танхимыг тохижуулах ажлыг чанар, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Насан туршийн суралцахуйн төв (Н.Насанжаргал)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА А.СҮХБОЛД

AJIL\2025 он ажил\захирамж

1225010235

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны ..04... дүгээр сарын ...22...-ны өдрийн
А/173... дугаар захирамжийн хавсралт

## ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

| д/д | Төрөл | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн зардал | Нийт зардал |
|---|---|---|---|---|---|
| 1 | Сургалтын хэрэглэгдэхүүн | багц | 10 | 78.540 | 785.400 |
| 2 | Хана болон шаланд аюулгүй орчин бүрдүүлэх (Чийгний гудас ) | ш | 6 | 60.000 | 360.000 |
| 3 | Микирфонтой өсгөгч | ш | 1 | 65.000 | 65.000 |
| 4 | ICD дэлгэц | ш | 5 | 12.000 | 60.000 |
| 5 | Lazybag (Залхуу сандал) | ш | 3 | 100.000 | 300.000 |
| 6 | Нимгэн хөнжил | ш | 4 | 20.000 | 80.000 |
| Дүн | | | | | 1.650.400 |